

Манзушир бурхны дүрийн ялгавар ба бэлгэдэл

Т.Булган, доктор (Ph.D), зөвлөх дэд профессор
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим
Ч.Батзориг, магистрант
МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим

Хураангуй: Буддын шашинд бурхны тухай ойлголт хамгийн өргөн цар хүрээтэй чухал сэдвийн нэг бөгөөд төдийлөн бүрэн гүйцэд судлагдаагүй сэдэв юм. Бурхан багшийн айлдсан “Хутагт Сайн хувьт”²¹ (Бурхан) сударт “Ертөнцөд гэгээрсэн бурхдын тоо хязгааргүй бөгөөд ирээдүйд гэгээрэх бурхдын тоо ч мөн адил хязгааргүй” хэмээн номлосон нь Буддын мэдлэг ухаан барагдашгүй далай адил гэдгийг илтгэдэг.

Бурхан багш бээр арван зүгийн бурхад, бодисадва нарын бүх алдрыг өгүүлснээс Манзуширын алдрыг өгүүлэх нь хамгийн их буянтай хэмээн айлдсан төдийгүй, бурхдын орны дотроос Манзуширын орныг дээдэд сайшаасан байдаг. Мөн “Богд Манзуширын лагшин босгох хийгээд түүнчлэн ажирсан бүхэн болгоолтын орны тийн номлолын дэлгэрэнгүй” (Бүдон, хууд. 5) (*rje btsun 'jam dbyangs kyi sku bzhengs tshul dang de bzhin gshegs ba kun gzigs kyi zhing khams kyi rnam bshad rgyas pa bu so*) хэмээх зохиолд Манзушир нь гурван цагийн бүх бурхдыг үүсгэх эх, өөрөөр хэлбэл тэдний билиг оюуны үүсэл мөн хэмээн тодорхойлж, бурхан болохыг хүссэн бодьгалсууд Манзуширыг шүтсэнээр гэгээрэлд хүрнэ гэж тайлбарласан байдаг. Манзушир бурхны гүн ухааны, номлол бэлгэдэл нь асар гүнзгий хийгээд түүний намтар цадиг, дүрслэл шүтээн урлалын бэлгэдэл утгыг харилцан уялдуулан, иж бүрэн байдлаар системтэй судлах нь Бурхан шашныг илүү их таньж мэдэхэд мөн шүтээн урлаач судлаач нар чухал ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Манзушир бурхны намтар цадиг, бэлгэдэл дүрийн шинжийг нэгдмэл байдлаар системтэй шинжилж, эдгээрт агуулагдах философи, гүн ухааны утга агуулгыг тодруулан тайлбарлахад оршино.

Түлхүүр үг: Манзушир; Буддын шүтээн урлал; Бэлгэдэл зүй; Бодисадва; Буддын гүн ухаан;

Манзушир бурхны илт онох дүр ба дүрийн ялгаврууд

Бурхад хамаг амьтны тусын тулд хувилгаан лагшны олон янзын дүрээр үзэгддэг. Бурхан багш бээр анх Шамбалын оронд Дүйнхор бурхны дүрээр тарнийн номоо айлдсан ба Замбуу тивд Очирдарь бурхны дүрээр тарнийн номоо айлдсан байдаг.

Манзушир бурхан ч мөн олон дүрүүдтэй бөгөөд тэдгээр нь хамаг амьтдын өөр өөрийнх нь сэтгэлд таацуулан энэрэн хайрлахын тухайд хувилан, түүнийг бурхны шашны урсгалууд өөрсдийн уламжлалд улам баяжуулан дэлгэрүүлсэн байдаг. Монголд язгуурын таван Манзушир болон түүний дошгин дүрүүд нэлээд дэлгэрсэн бөгөөд ялангуяа Гэгвийдоржийн цагаан Манзушир оюун билиг хайрлахын зэрэгцээ нинжин сэтгэл, яруу өгүүлэхийн эрдмийг хайрладаг гэж үздэг.

Бурхдыг гадаад дүр байдлаар нь амарлингуй, хагас хилэнт, хилэнт догшин гэсэн үндсэн гурван ялгаварт авч үздэг. Манзушир бурхныг дүрийн хувьд:

²¹ Бурхан багшийн айлдсан Доди галсан судар

- Амирлангүй дүрт- (шар Манзушир, цагаан Манзушир)
- Хагас хилэнт дүрт -(хар Манзушир)
- Хилэнт догшин дүрт- (Ямандаг, Чойжил, Лусыг сахигч) гэх зэрэг олон дүр байдаг.

“Их Монголын Бурхны шашны урлах ухааны үндсэн мэдэгдэхүүн ”-д номд (Г.Пүрэвбат, 2017, хуудсд. 120,121) Амирлангүй дүрт бурхан нь дияанд оршсон болоод нигүүлсэл төгөлдөр, талимаарсан бөгөөд тачаал төгөлдөр, мишээсэн, уян эелдэг, гунхан найгасан, идрийн байдалтай буй. Амарлингуй эр бурхдын лагшин байдал нь махлаг, чийрэг, цээж дөрвөлжин, доод бие зэргэмжээр нарийссан нь гадас лугаа адил. Энэ мэт амарлингуй бурхдын чуулган бүгдийн амарлингуй ёсны есөн эрдмийг

1. Зөөлөн эелдэг
2. Уян налархай буюу намилзан уйлгалсан
3. Туялзсан
4. Гунхсан
5. Идрийн мяраа тогтсон
6. Саруул буюу ариун тодорхой
7. Гэрэлтсэн
8. Сүр жавхлант
9. Цог адис машид бадарсан хэмээжээ.

1. Зөөлөн эелдэг нь омог арилснаар зовлонгийн дөрвөн их мөрөнг ахуйд нь ариусган лагшинд зөөлөн эелдэг мах тогтсон.
 2. Уян налархай хэмээсэн нь уур арилснаар лагшны үес гишүүн хэр таарсан тул уян налархай буюу туялзсан.
 3. Намилзан уйлгалцсан хэмээсэн нь тачаал арилснаар лагшин үзэмжтэй гуа болоод намилзан уйлгалцсан.
 4. Гунхалзсан хэмээсэн нь атаа арилснаар лагшин цэх шулуун болоод гунхалзсан
 5. Идрийн мяраа тогтсон хэмээсэн нь мунхаг арилснаар лагшинд зөөлөн болоод идрийн мах тогтсон тул төрөлх чанар идрийн мяраатай болсон. Эдгээр нь “мөн чанарын эрдэм” болой.
 6. Саруул хэмээсэн нь эс мэдэхүйг тэвчсэнээр лагшин ариун, өнгө тодорхой саруул
 7. Гэрэлтсэн хэмээсэн нь цувиралт төрөн түгэхүйг гүйцээснээр лагшин дурьтмал тунгалаг болоод гэрэлтсэн өнгөтэй
 8. Сүр жавхлант хэмээсэн нь бэлгэ найраг төгссөнөөр сүрлэг хийгээд сэтгэлд зохистойгоор сүр жавхлантай
 9. Цог адис машид бадарсан хэмээсэн нь бүхнийг сүрээр дарснаар цог адис лугаа төгөлдөр эдгээрийг “байдлын эрдэм”-д номлосон. Амирлангүй эцэг бурхдын дүр байдлын эрдэмд эдгээрийн дээр нэмээд
1. Таалал нь мунхгийн түйтгэр үгүй тул саран мэт саруул
 2. Эрдэм нь дэлгэрсний дохионд наран мэт гэрэлтсэн
 3. Бэлгэ найрал бүрдсэний дохионд уулсын хаан мэт сүр жавхлант
 4. Бүхнийг сүрээр дарсны шинж нь чандмань мэт цог адис төгс хэмээжээ.

Шар Манзуширын ондог буюу илт онохуйн дүр нь: “Их Монголын Бурхадын лагшин дүрийн хувь хэмжээний шугамын онол” номд (Г.Пүрэвбат, 2017, хууд. 115)

шар Манзушир бурхныг дүрслэн бичихдээ “Хутагт Зөөлөн эгшигт Манзушир бурхны лагшны өнгө гүргэмийн туяа туссан мэт улбар шар өнгөтэй амарлингуй сайхан байдалтай, нэгэн нүүр хоёр мутартай, баруун мутраар мунхгийн үндсийг ёзоороор нь

тастагч билгийн илдийг огторгуйд далайсан, зүүн мутраар удвал цэцгийн ишийг эрхий болон ядам хуруугаар зүрхэн тушаа барьсны цэцгийн дэлбээ нь чихний харалдаа ирсний дээр “Билгийн чанадад хүрэхүй”-н судрыг агуулсан. Өлмий очир завиллаар оршсон бөгөөд эрдэнийн элдэв чимгээр чимсэн, элдэв торгон хувцас соёрхсон бөгөөд идэр залуу 16 насны дүр байдалтай, үснирийг шанхлан тав цомоглож, 32 лагшин, 80 найраг буюу лагшингийн 112 эрдмээр чимсэн, төгс жаргалангийн лагшинтай, сарны гэрлэн түшлэгийг эрхшээж тунгалаг тодорхой гэрлийн мөн чанартай оршино” хэмээн ихэнх сударт товч тодорхой бичсэн байдаг.

Энэхүү илт онох дүрийг задлан тайлбарлах ялангуяа Манзуширын дүрээр илэрхийлж байгаа бүхий л зүйлс буддын философи, гүн ухааны бэлгэдэл, урлагаар дамжуулж, амар амгалан төгс гэгээрэлд хүргэх арга замыг бэлгэдэн шингээсэн байдаг. Тэгэхээр төгс гэгээрсэн бурхны бие лагшин хэдэн төрөл байх, яаж хувьсан өөрчлөгддөг талаар Алтангэрэл сударт: “Төгс жаргалангийн лагшин хэмээх нь бурхны лагшныг дотор нь номын лагшин ба дүрст лагшин хэмээгээд мөн дүрст лагшныг дотор нь төгс жаргалангийн лагшин хийгээд хувилгаан лагшин гэж хоёр хуваана. Төгс жаргалангийн лагшин нь амьтны тусыг бүтээхийн тулд эгэл амьтдын санаа бодолд тааруулахын тулд эгэлийн хувилгаан дүрээр ирж амьтны тусыг зохиож байдаг. Эдгээр гурван бие лагшин нь урьд өмнө тэдний үйлдсэн буян хийгээд ерөөлийн үр шимээр бүтдэг.” гэсэн байна. (С.Гантөмөр, хууд. 31)²²

Манзушир бурхны лагшны өнгө гүргэмийн туяа туссан мэт хэмээсэн нь: Гүргэм гэдэг нь улбар шар өнгөтэй олон наст өвслөг ургамал ба уламжлалт анагаах ухаанд цус шингэлэх элэгний өвчин бүхнийг арилган судлын амыг бооно гэсэн бөгөөд олон эм тангийн найрлагад ордог, бурхан шашны зан үйлэнд рашаан хийх болон тахилын усанд тавих мөн ариусгах чанартай сайн зургаа гэх мэт олон эд зайны найрлагад ордог. Монгол уламжлалт бэлгэ зүйд улбар шар өнгө нь нарны дулаан илч, билгийн гал, ухаан билиг, өөдрөг сэтгэл, оюун ухааныг илэрхийлдэг бол орчин үеийн сэтгэл судлалын мэргэжилтнүүд “Улбар шар өнгө хүний сэтгэл зүйд ихэвчлэн бясалгал, энэрэн нигүүлсэхүй зэрэг оюун санаатай холбоотой мөн буддын шашны лам нар энгийн байдал, материаллаг үзлээс ангижрахыг бэлгэдэн улбар шар өнгийн хувцас өмсдөг байна. Энэхүү уламжлал нь Буддагийн үеэс хэдэн мянган жилийн өмнө үүссэн” (<https://www.verywellmind.com/the-color-psychology-of-orange>), бөгөөд улбар шар өнгөтэй холбоотой эерэг үгс нь: дулаан, аюулгүй байдал, хүсэл тэмүүлэл, элбэг дэлбэг байдал, хөгжилтэй, нийгэм, найрсаг, амьд байдал, идэвхтэй, аз жаргал, баяр баясгалан, хөгжилтэй, итгэлтэй, эрч хүчтэй, экстраверт” гэх сэтгэлзүйн төлөвийг илэрхийлдэг өнгө (<https://www.inspiredspaces.com.au/psychological-effects-of-colours/>) гэж үзжээ.

Манзушир бурхны эх бурхан нь Янжинлхам бөгөөд Цахар гэвш Лувсанцүлтимийн “Хамгийг айлдагч Богд Зонховын цадиг мэдэхүйеэ хялбараар өгүүлсэн сайн амгалан бүхэн гарахын орон хэмээгдэх оршвой” номд “Манзушир нь үлэмж ядам бурхан бөгөөд магад Сараваст²³ нь онолын эрдмийг өгөгч эх болмуй. Магад их бодийг олмуй” (Д.Наранцэцэг, 2004, хууд. 42) гэсэн байна.

Манзушир бурхны мутрын барьц түүний бэлгэдэлт утга

Буддын шашинд бурхдыг лагшин, зарлиг тааллын шүтээнээр төлөөлүүлэн бэлгэддэг. Лагшны шүтээн гэдэг нь амарлингуй, хилэнт, хагас хилэнт бурхдын дүрийг олон янзаар бүтээснийг хэлнэ. Зарлигийн шүтээн гэдэг нь тухайн бурхны хөрөнгө үсгээр нь

²² Төвөд хэлнээс орчуулсан гавж С.Гантөмөр “Алтангэрэл судрын 3-р бүлгээс”

²³ Санскрит нэр нь Сарасвати, Төвөдөөр Янжинлхам, Монголоор Эгшиглэнт эх

төлөөлүүлэн бэлгэддэг. Тааллын шүтээн гэдэг тухайн бурхны мутрын барьц тэмдгээр нь төлөөлүүлэн бэлгэддэг байна. Тэгэхээр мутрын барьц нь тухайн бурхны гол бэлгэдэл номын утга санааг илэрхийлж байдаг бөгөөд мөн бурхнаа төлөөлж бэлгэддэг байна.

Манзушир бурхан нь баруундаа бэлгэ билгийн илд далайсан зүүн мутартаа удвал цэцгийн дээр билиг барамидын судар тавьсныг ишнээс нь зүрхний харалдаа барьсан байдаг.

Баруун мутрын барьцад билгийн илдийг далайсан түүний утга: Хоосон чанарыг оносон билгүүнээр мунхгийг арилган зовлонгийн үндсийг таслахыг бэлгэдсэн хос иртэй илд түүний их биеийг ороон үзүүр нь дээш бадарсан бэлгэ билгийн галтай, бариулын үзүүртээ 5 эвэрт очиртой байдаг. Энэ нь орчлонгийн зовлон бүгдийн үндэс болсон мунхаг сэтгэлийг ёзоороор нь тас цавчихыг бэлгэдэл болдог. Галын бүхнийг шатаан түлэх, ариусгах чанараар нь оромжлон сэтгэлийн таван хорыг даран урвуулах билгийн галаар төлөөлүүлэн ердийн галд түлэгддэггүй бүхнийг билгийн галаар шатаа хэмээсэн бөгөөд мунхаг харанхуйг гэрэлтүүлэх, мөн бүгдийг ариусгах хүч чадалтайгаар нь тийнхүү бэлгэдсэн байна.

Зүүн мутрын удвал цэцгийн бэлгэдэл утга: Удвал цэцэг нэгэн ишнээс гурав салаалсны голын цэцэг нь одоо цагийг бэлгэдэн дэлбээлсэн, баруун ишинд өнгөрсөн цагийг бэлгэдэн үр боловсорсон хонгорцгийн байдалтай, зүүн ишинд ирээдүй цагийг илтгэн цоморлогийн байдалтай байдаг нь өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн байна. Бурхны шашинд арван зүгийн гурван цагийн хэмээн цаг зүгийг маш чухал авч үздэг нь өнгөрсөн цаг буюу үйлээс одоо цагийн үйл бүтнэ, одоо цагийн үйлээс ирээдүйн үйл бүтнэ хэмээх үйл үр, шүтэн барилдлагын хуулийг харуулсан бэлгэдлийг илэрхийлдэг байна.

Зүүн мутраар удвал цэцгийн дээр судар барьсан утга нь: Манзушир бурхныг бурхан бүгдийн билиг оюуны дүрсэнд бэлгэдэж түүний зүүн мутрын барьцад удвал цэцгийн дээр Пражна прамита буюу билиг барамидын судрыг тавьсны үзүүрээс барьсан нь хоёр түйтгэрийг ялж, хоёр бодь сэтгэл²⁴-ийг төгс болгож, хоосон чанарыг илт оносон билгүүнээр гэгээрч, бурхан болохыг бэлгэдсэн байна. Энэ нь аливаа хүн гэгээрэхийг хүсвээс бурхны айлдсан билиг барамид хийгээд хоосон чанарын сургаал номыг сонсож, санаж, бясалгах хэрэгтэйг сануулсан бэлгэдэл. Цэцэг чихний харалдаа байх нь сонсох, санахыг анхааран авахын дохио, аглагийн оронд дотоод өөрийн үндсэн дээр бясалгаваас над лугаа адил эрдэнийн чимгийг олно хэмээсэн нь номын дээр байгаа чандмань эрдэнээр, гадна талд сэтгэгчилэн бүтэх эрдэнийн чимэг байхчилан дотоодод ч гүнзгий их билиг тэргүүтэн эрдэнийн чимэг буйг бэлгэдсэн.

Ном номлох мутарлаг нь эрхий хийгээд, долоовор хоёр хурууны үзүүрийг учруулснаар арга, билиг хоёр хослон барилдахыг бэлгэдсэн хийгээд дунд хуруу, нэргүй, чигчий хуруу гурвыг дээш босгосноор гурван төрөлхтнийг мөрийг зэрэгчилэн хөтлөхийг бэлгэдсэн. Мутарлахыг зүрхэн тушаа агуулснаар эрдэм бүгд өөрийн дотор буй хэмээсэн хийгээд туулсан бодийг хүсэн тэмүүлэх энэ нь үлэмж үзэл болно гэжээ.

Пражна прамита буюу билиг барамидын ном-ыг анх бурхан багш Ражигир хотын зүүн хойно орших Тас цогцолсон хэмээх ууланд өөрийн шавь Шаарийпудра, Ананда тэргүүтэй хуврагуудад номлосноор их хөлгөний номлолыг дэлгэрүүлжээ. Билиг барамидын гол утга нь юу байх вэ гэвэл энэ нь илт, далд гэсэн хоёр утгаар

²⁴ Ерөөхүйн бодь сэтгэл, орохуйн бодь сэтгэл гэж 2 байна. Ерөөхүйн бодь сэтгэл нь зургаан барамидын үйлээр үл эзлэгдсэн бодь сэтгэл, орохуйн бодь сэтгэл нь зургаан барамидын үйлээр эзлэгдсэн бодь сэтгэл юм.

тайлбарлагдана. Энэ нь шууд утгадаа юмс бүгдийн хоосон чанарыг үзүүлсэн тул хоосон чанарын сургаал хэмээн нэрлэгдэх боловч гүнзгий утгандаа гэгээрэлд хүрэх мөрийн дэс дарааллыг үзүүлдэг байна.

Манзушир бурхны суудлын бэлгэдэл утга

Бурхдын орших байдлыг суух байдлын ялгавар, зогсох байдлын ялгавар, бүжиглэх байдлын ялгавар гэж үндсэн 3 хувааж, үүнээс суух байдал нь 16 байна гэж “Их Монголын Бурхны шашны урлах ухааны үндсэн мэдэгдэхүүн”-номд (Г.Пүрэвбат, 2017, хууд. 135) бичсэн байна. Манзушир бурхан нь очир завилгаагаар оршсон байдаг. Очир завилгаа гэдэг нь зүүн хөлийн шилбээ хумин өлмийн толиог дээш харуулан баруун гуяны дунд тааруулан тавина. Түүний дээр баруун хөлийг татан өлмийн толиог дээш харуулан урьд мэт зүүн гуяны дээр тавьж хоёр хөлөө солбиулан суухыг очир завилгаа гэнэ.

“Самади” бясалгалын сурах бичиг номд: “Өөрийн оюун лугаа зохилдсон буюу сэтгэлд зохистой машинд зөөлөн дэвсгэрийн дээр дээрх адил суухыг очир завилгаа хэмээгээд хоёр хөл очир завиллаар орших нь өөрийн биед буй их гол хий, амь баригч ба уруу арилгагч хий, дээш гүйгч хий, түгээгч хий, тэгш оршигч хий сэлт үндсэн таван хий байхаас уруу арилгагч хий нь төв судалд орсноор атгаг сэтгэл хаагдах ба дияаныг зэтгэрээр хөдөлгөхгүй хэрэг буй хэмээсэн. Энэ нь самади дияан болон амарлин орших буюу сэтгэлийг тогтоон барих бясалгалын үед биеийг оньслон бэлдэх, сэтгэлийг тогтоон барих болон онол сэтгэлд ургана гэж үздэг бөгөөд Гэгээн гэрэлт бурхны орших 7 зүйл суудал” (Д.Бямбасүрэн, 2006, хууд. 17) хэмээсэн байна.

Манзушир бурхны чимэг зүүлт, хувцасны бэлгэдэл утга

Бурхны гурван зүйл лагшны нэг болох төгс жаргалангийн лагшинд өргөх их эрдэнийн найман чимэг хийгээд таван торгон хувцас буй бөгөөд нийлээд арван гурав чимэг, хувцас гэдэг. Найман чимэг үүнд: Титэм, ээмэг, хоолойвч, мутрын бугуйвч, урт богино унжлага хоолойвч, бөгж, манжлагат бүс, бойвгийн шагайвч.

Таван торгон хувцас үүнд: Титэмлэх манжлагат бүч, цээживч, урт хивэн нөмрөг, бүс, хормойвч хэмээжээ.

Чимэг хувцас эдгээрийг их хөлгөний ёсоор билиг ухааны чанадад хүрч гэгээрэх аргын суурь зургаан барамид болох өглөгийн барамид, шагшаабадын барамид, хүлцэнгүйн барамид, хичээнгүйн барамид, тэвчээрийн барамид, дияаны барамид, билгүүний барамид үүн дээр нэмээд арга мэргэний барамид, ерөөлийн барамид, хүчний барамид, бэлгэ билгийн барамид зэрэг арван барамид лугаа барилдуулан бэлгэдсэн байдаг.

Манзушир бурхны суурийн бэлгэдэл утга

Их Монголын бурхан шашны урлах ухааны үндсэн мэдэгдэхүүн номд: Лянх цэцэг бээр балчгаас төрдөг ч балчгийн гэмээр халдаагдаагүй байдагчлан эгэл төрөлхтөн бүгд үйл нисваанисаар түйтгэрлэгдэн, сансрын орноо төрсөн боловч ариун номлолоор тэтгэгдэн, ертөнцийн хирийг хоцроолгүй арилгаснаар магад гарахыг бэлгэдэж буй юм. Мөн хүйсэн дээр нь залсан наран, саран хоёр нь арга билигт шүтсэнээр амгалан хоосон хоёргүй хослон орох бэлгэ билгийг бүтээхийг бэлгэддэг. Бурхдын дүрийг лянхуа цэцгэн дээр залж, дүрслэх нь эгэл хүний гэгээрэлд хүрч, гэм бүхнээ ялан дийлж чадагчийн хутгийг олохын бэлгэдэл юм.

Лянхуа цэцгийн дээр залсан нарыг улаан, сарыг цагаан өнгөөр дүрслэх нь арга билгийн гүн ухааныг илэрхийлнэ. Арга билиг гэдэг нь юмсын эерэг ба сөрөг, харилцан шүтэлцээт хоёр талыг нэгдэлд оруулан учир зүйг танин мэдэх дорно дахины философийн суурь ойлголт бөгөөд аргын хүчээр билигт хүрч, билигт тулгуурлан арга

төгөлдөржинө гэж үздэг. Иймээс арга, билиг тэнцвэртэй байх нь аливаа оршихуйн жам ёсны тэнцвэрийг хангах үндэс болдог.

“Амгалан хоосон хоёргүй хослон орох” хэмээх ойлголт нь хоосон чанарыг танин ухаарснаар мунхаг сэтгэл арилж, мунхаг арилснаар зовлон үгүй болж, улмаар зовлонгоос ангижрахуй нь амгалан нирваанд хүрэхүйг заана. Энэ утгаараа амгалан ба хоосон чанар нь угтаа салангид бус, нэгэн мөн чанар бөгөөд түүгээр дамжин Чадагчийн эрхтийн хутаг буюу бүх гэмийг ялан дийлж, төгс гэгээрэлд хүрсэн бурхан болох утга агуулгыг илэрхийлж байна.

Буддын урлаг хийгээд бурхны дүр нь хүний жинхэнэ мөн чанар болох дээд эрдэм мэдлэг, өөрөөр хэлбэл гэгээрэлд хүрэх танин мэдэхүйн ном сургаалыг бэлгэдэн илэрхийлдэг бөгөөд буддын философи, гүн ухааны үзэл санааг урлаг, гоо зүйн хэлбэрээр дамжуулан төгс гэгээрэлд хөтлөх ойлголтыг илтгэдэг нь Бурхны шашны онцлог юм.

Ном зүй

Богд Зонхов, орч Г.Пүрэвбат. 2002. Бодь мөрийн зэрэг. Улаанбаатар.

Бүдон, Р. (1290-1364). Богд Манзуширын лагшин босгох хийгээд түүнчлэн ажирсан бүхэн болгоолтын орны тийн номлолын дэлгэрэнгүй. Төвөд.

Г.Пүрэвбат. (2017). Их Монголын Бурхадын лагшин дүрийн хувь хэмжээний шугамын онол. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Г.Пүрэвбат. (2017). Их Монголын Бурхны шашны урлах ухааны үндсэн мэдэгдэхүүн-2. Улаанбаатар : Мөнхийг үсэг хэвлэлийн газар.

Д.Бямбасүрэн. (2006). “Самади” бясалгалын сурах бичиг . Улаанбаатар: Шамбал нийгэмлэг.

Д.Наранцэцэг. (2004). Хамгийг айлдагч Богд Зонховын цадиг мэдэхүйеэ хялбараар өгүүлсэн сайн амгалан бүхэн гарахын орон хэмээгдэх оршвой. Улаанбаатар .

С.Гантөмөр, Г. (2008). Бурхан багшийн айлдсан Алтангэрэл судар. Улаанбаатар: Бодь мөр принтинг.

Ш.Чоймаа, Л.Тэрбиш, Д.Бүрнээ, Л.Чулуунбаатар. 2015 он. Буддын шашин, соёлын тайлбар толь Улаанбаатар хот: Соёмбо пресс.

Differences and symbols of the image of Manjushri Buddha

In Buddhist studies, the concept of the Buddha represents one of the most comprehensive and fundamental themes, yet it remains insufficiently explored in a systematic manner. According to the sutra The Noble Fortunate One, the Buddha taught that “the number of Buddhas who have attained enlightenment in the world is limitless, and likewise, the number of Buddhas who will attain enlightenment in the future is also limitless,” thereby emphasizing the boundless nature of Buddhist wisdom.

The Buddha further proclaimed that, among the praises of all Buddhas and bodhisattvas of the ten directions, the veneration of Mañjuśrī yields the greatest merit. Moreover, among all Buddha realms, the pure land of Mañjuśrī is extolled as supreme. In An Extensive Commentary on the Manner of Constructing the Sacred Body of the Venerable Mañjuśrī and the Pure Land of the Thus-Gone All-Seeing One by the eminent scholar Budön Rinchen Drub (p. 5), Mañjuśrī is identified as the source of all Buddhas of the three times—that is, the

origin of their transcendent wisdom. It is also asserted that sentient beings who aspire to attain Buddhahood may reach enlightenment through devotion to Mañjuśrī.

Despite the profound philosophical, doctrinal, and symbolic significance of Mañjuśrī, to date there has been no sufficiently comprehensive and systematic study that integrally examines his hagiography, iconography, and the symbolic meanings embedded in devotional representations.

The aim of this study is to undertake a systematic and integrated analysis of the hagiographical narratives and symbolic attributes of Mañjuśrī, and to elucidate the philosophical and doctrinal meanings embodied within them.